Баянхонгор аймгийн ОНӨГ-ын үндсэн хөрөнгө өмнөх оноос 2,606,915.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн зардлаас 3,405.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, эрх бүхий байгуулагуудын шийдвэрээр 2,653,616.8 мянган төгрөгийн 10 үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй “Чандмань Баянхонгор” ХК-ийн урт хугацаат өр төлбөрийг Сангийн яамнаас хоорондын тооцоогоор бууруулсантай холбоотой өр төлбөрийн дүн 967,077.3 мянган төгрөгөөр буурч 3,367,922.7 мянган төгрөг болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,729,450.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, урт хугацаат зээлийн өр төлбөрийг 967,077.3 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой өмнөх үеийн үр дүн дансанд өөрчлөлт орж, Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,643,485.9 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 357,241.5 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянга, нийт зарлагыг 367,241.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 82,413.0 мянган төгрөгөөр бууруулж, 274,828.5 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардлыг хасч баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 69,740.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 344,298.5 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, хангамж, бараа материалын зардал, томилолтын зардлуудыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,251.8 мянган төгрөгөөр тасарсан ба үүнээс шалтгаалан төсвийн нийт зардлын гүйцэтгэл 340,231.1 мянган төгрөг буюу нийт төлөвлөсөн зардлын 98.8 хувьтай байсан, оны эцэст зардлын хэмнэлтийн 815.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	265,344.7	262,010.1	3,334.6	98.9
2	Ажил олгогчоос төлөх НДШ	33,168.1	32,441.6	726.5	99.9
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120.0	120.0	-	100.0
4	Хангамж Бараа материалын зардал	18,622.0	18,620.0	2.0	100.0
5	Эд хогшил урсгал зардал	6,200.0	6,195.8	4.2	100.0
6	Томилолт зочны зардал	13,904.0	13,904.0	-	100.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,439.7	5,439.5	0.2	100.0
8	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,500.0	1,500.0	-	100.0
	дүн	344,298.5	340,231.1	4,067.4	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар “Бона Вита” ХХК-ийн түрээсийн төлбөрийн 982.8 мянган төгрөгийн орлого орсныг оны эцэст орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2023 онд худалдан авах ажиллагаа байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 344,298.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,442.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,410.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчил өмнөх онд давтагдан гарсан тул байгууллагын нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн байхад 2023 оны мэдээллээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 186,508.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3,169.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлах 1 тушаал болон аудитын тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй зөрчил дахин илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт авч, аудитын тайлангаар 38,933.5 мянган төгрөгийн 3 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан бичгээр хариуг ирүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10,325.70	1	10,325.7	100
Албан шаардлага	1	30,255.30	1	30,255.30	100
Зөвлөмж	1	1,467.50	1	1,467.50	100
Залруулга	3	54,501.40	3	54,501.40	100
Нийт дүн	6	96,549.90	6	96,549.90	100

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт, материал

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн ОНӨГ-ын санхүүгийн тайлангийн бусад хангамжийн материал дансанд 2021 онд 30,000.0 мянган төгрөг бүртгэсэн нь аймгийн Онцгой байдлын газрын Ланд-200 маркын суудлын автомашинтай холбоотой, бараа материалд бүртгэлтэй

байгаагаас шалтгаалан тус үндсэн хөрөнгөд элэгдэл тооцохгүй байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,142.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад авлага, бараа материалын тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн 142.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй авлагыг нэмэгдүүлж залруулсан.
2. Тайлант онд зарцуулсан 9,000.0 мянган төгрөгийн шатахууны тайланг байгууллагын нярав шатахууны сар бүрийн тайлангуудыг хасах үлдэгдэлтэй тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байгаа нь Тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй тул бараа материалын тайланг залруулсан.

Аудитаар нийт 2,086.7 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 2,086.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, өмнөх аудитаар өгсөн шийдвэрүүдийг хангалтгүй биелүүлсэн байгууллагын нягтлан бодогчид хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн 2,086.7 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 68 дугаар захирамжийн дагуу тус байгууллагын дарга 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 3126951 регистрийн дугаартай “Бадамлан асах жаргал” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж, Жинст сумын эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг 4,386,670 (Дөрвөн сая гурван зуун наян зургаан мянга зургаан зуун далан) төгрөгөөр худалдан авч, 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор уг төлбөрийг хийхээр гэрээнд заасан байна.

“Бадамлан асах жаргал” ХХК 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 2,300,000 (Хоёр сая гурван зуун мянган) төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дансанд шилжүүлж, 2,086,670 (Хоёр сая наян зургаан мянга зургаан зуун далан) төгрөгийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, гэрээний биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалт, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, “Бадамлан асах жаргал” ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний 3.4 дэх “Худалдан авагч нь гэрээ албан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ёсоор байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор буюу 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 18 цаг 00 минутаас өмнө эд хөрөнгийн 4,386,670 төгрөгийг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жинст сумын Эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг худалдан борлуулсны орлогын 2,086,670 төгрөгийг “Бадамлан асах жаргал” ХХК-аар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн байхад 2023 оны мэдээллээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 186,508.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3,169.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлах 1 тушаал болон аудитын тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй, бараа материалын тайланг зөрүүтэй бэлтгэсэн зөрчлийг 2023 онд давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Төрийн аудитын тухай хуулийн 42, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллаагүй, зөрчлийг дараа онд давтан гаргаж, албан үүргээ биелүүлж ажиллаагүй байгууллагын нягтлан бодогч Л.Дуламсүрэнд хариуцлага тооцох албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын шимтгэлийн 142.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	142.4					1	142.4				
Байгууллагын нярав 2023 оны шатахууны тайлангуудын хасах үлдэгдэлтэй тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна.	1	9,000.0					1	9,000.0				
Дүн	2	9,142.4	0	0	0	0	2	9,142.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 68 дугаар захирамжийн дагуу тус байгууллагын дарга 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 3126951 регистрийн дугаартай "Бадамлан асах жаргал" ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж, Жинст сумын эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг 4,386,670 төгрөгөөр худалдан авч, 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор уг төлбөрийг хийхээр гэрээнд заасан байхад 2,086.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	1	2,086.7	1	2,086.7								
Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн байхад 2023 оны мэдээллээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 186,508.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 3,169.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлах 1 тушаал болон аудитын тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй, бараа материалын тайланг зөрүүтэй бэлтгэсэн зөрчлийг 2023 онд давтан гаргасан байна.	1	-							1	0		
Дүн	2	2,086.7	1	2,086.7	1	-	0	-	0	0	0	0

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 14 / А0560238 / БНА
2024 / 177 / АА - СТА - ТУБ

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 68 дугаар захирамжийн дагуу тус байгууллагын дарга 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 3126951 регистрийн дугаартай “Бадамлан асах жаргал” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж, Жинст сумын эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг 4,386,670 (Дөрвөн сая гурван зуун наян зургаан мянга зургаан зуун далан) төгрөгөөр худалдан авч, 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор уг төлбөрийг хийхээр гэрээнд заасан байна.

“Бадамлан асах жаргал” ХХК 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 2,300,000 (Хоёр сая гурван зуун мянган) төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дансанд шилжүүлж, 2,086,670 (Хоёр сая наян зургаан мянга зургаан зуун далан) төгрөгийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, гэрээний биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалт, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, “Бадамлан асах жаргал” ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний 3.4 дэх “Худалдан авагч нь гэрээ албан ёсоор байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор буюу 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 18 цаг 00 минутаас өмнө эд хөрөнгийн 4,386,670 төгрөгийг Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын

5050044

Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.2 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Жинст сумын Эргэлтийн эмийн сангийн хөрөнгийг худалдан борлуулсны орлогын 2,086,670 (Хоёр сая наян зургаан мянга зургаан зуун далан) төгрөгийг “Бадамлан асах жаргал” ХХК-аар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 11-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх, нягтлан бодогч Л.Дуламсүрэн нарт даалгав^{2, 3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 21/А0560238/БМА
2024/177/НА-СТА-ТМБ

Номгон

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхонгор аймгийн ОНӨГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрч албан шаардлага өгсөн байхад 2023 оны мэдээллээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 186,508,000 (Нэг зуун наян зургаан мянга таван зуун найм) төгрөгийн орлогын гүйлгээ, 3,169,181 (Гурван сая нэг зуун жаран есөн мянга нэг зуун наян нэг) төгрөгийн хөрөнгийг актлах 1 тушаал болон аудитын тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй, бараа материалын тайланг зөрүүтэй бэлтгэсэн зөрчлийг 2023 онд давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1,

5040064


D/2024-ASH


42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10 дахь “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч Л.Дуламсүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 03 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнхөд даалгав².

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:  Б.ДОЛЖМАА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор хот, 1 дүгээр баг, Нутгийн удирдлагын ордон. Утас: 7044-2584

² Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.